



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.24 № 290

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**МАНДАЛ-ОВОО СУМЫН  
АРГАМЖИНЦЭЦЭГ ОНӨААТҮГ-Т**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд 2022 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудитын тайлан, дүгнэлт, албан шаардлагыг хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
Ц. ӨСӨХБАЯР



D/Явсан Бичиг/2023он/2023-03-24.Дос

016030212



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.08.15 № 217

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мандал-Овоо сумын Аргамжинцэцэг ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Мандал-овоо сумын Аргамжинцэцэг ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"-д заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант онд 1.9 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Аргамжинцэцэг ОНӨААТҮГ нь бизнес төлөвлөгөөнд тусгасан борлуулалтын орлогоос 11.2 сая төгрөг буюу 23.1 хувиар илүү орлого төвлөрүүлсэн байна.

• 016020289





ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 188/А1671117

Даланзадгад сум

ӨМА-2023/22/НА-СТА-ОНА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мандал-Овоо сумын "Аргамжинцэцэг" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд

Санхүүгийн тайланд тусгасан 1,908,721.00 төгрөгийн авлага, 619,537.38 төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"-д заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасныг хэрэгжүүлэн биелэлтийг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мандал-Овоо сумын Аргамжинцэцэг ОНӨААТҮГ-ын захирал (Ц.Ууганцэцэг), нягтлан бодогч (Б.Алтантуяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ц.ӨСӨХБАЯР

Т.БУДСҮРЭН





ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Мандал-овоо сумын Аргамжинцэцэг ОНӨААТҮГ-н 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ӨМА-2023/22/НА-СТА-ОНА**

Цахим хуудас:  
[www.Umnugovi@audit.mn](http://www.Umnugovi@audit.mn)

Өмнөговь аймаг  
2023 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: [usukhbayarts@audit.gov.mn](mailto:usukhbayarts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: [Khongorzult@audit.gov.mn](mailto:Khongorzult@audit.gov.mn)  
Аудитор: Т.Будсүрэн  
Утас: 70533552 Цахим хаяг: [budsurent@audit.gov.mn](mailto:budsurent@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....	8
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	9
4. Аудитын тайлан.....	10
4.1 Ерөнхий зүйл .....	10
4.2 Материаллаг байдал .....	10
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
5. Аудитын илрүүлэлт.....	12
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон Нутгийн Өмчит Аж Ахуйн Тооцоот Үйлдвэрийн Газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг 46083  
Утас: (976) 7053 3539. Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: omnugovi@audit.gov.mn

2023.08.15 № 217

Тайлбар: \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

МАНДАЛ-ОВОО СУМЫН  
АРГАМЖИНЦЭЦЭГ" ОНӨААТҮГ-  
ЫН ЗАХИРАЛ Ц.УУГАНЦЭЦЭГ  
ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мандал-Овоо сумын Аргамжинцэцэг ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Мандал-овоо сумын Аргамжинцэцэг ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"-д заасантай нийцээгүй. нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант онд 1.9 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Аргамжинцэцэг ОНӨААТҮГ нь бизнес төлөвлөгөөнд тусгасан борлуулалтын орлогоос 11.2 сая төгрөг буюу 23.1 хувиар илүү орлого төвлөрүүлсэн байна.

☎ 016020799

### **Аудитын гол асуудал**

Аргамжинцэцэг ОНӨААТҮГ нь 61.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 58.2 сая төгрөгийг зардал гарган, 3.4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,858,544.35</b>	<b>7,721,109.41</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	124,776.74	599,886.92
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	124,776.74	599,886.92
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	124,776.74	599,886.92
31213	Арилжааны банк дахь харилцах	124,776.74	599,886.92
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	342,286.00	1,908,721.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	342,286.00	-
33401	Дансны авлага /ТӨҮГ/		1,908,721.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	5,391,481.61	5,212,501.49
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	5,044,072.52	4,792,492.40
35130	Эм боох материал	5,044,072.52	4,792,492.40
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	347,409.09	420,009.09
35420	Аж ахуйн материал	347,409.09	420,009.09
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>59,209,000.48</b>	<b>57,603,333.81</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	59,209,000.48	57,603,333.81
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	58,386,000.40	56,906,333.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	64,800,000.00	64,800,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	6,480,000.00	8,100,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	70,000.00	70,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	13,999.92	20,999.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	251,420.00	260,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	241,419.68	102,666.35
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	671,000.08	545,000.08
39301	Програм хангамж	1,289,000.00	1,224,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	617,999.92	678,999.92
<b>394</b>	<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>	152,000.00	152,000.00
39405	Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/	152,000.00	152,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>65,067,544.83</b>	<b>65,324,443.22</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>60,496,502.24</b>	<b>57,319,537.38</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,176,502.24	619,537.38
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,176,502.24	619,537.38
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	757.00	
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	2,175,745.24	619,537.38
41361	Байгууллагад төлөх өглөг	1,460,000.00	
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	715,745.24	619,537.38
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	58,320,000.00	56,700,000.00
<b>422</b>	<b>Урт хугацаат зээл</b>	58,320,000.00	56,700,000.00
<b>4222</b>	<b>Гадаад валют</b>	58,320,000.00	56,700,000.00
42229	Хойшлогдсон татварын өр /ТӨҮГ/	58,320,000.00	56,700,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,571,042.59</b>	<b>8,004,905.84</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,571,042.59	8,004,905.84

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,359,613.00	9,359,613.00
51101	Өмч: - төрийн	9,207,613.00	9,207,613.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	152,000.00	152,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(5,295,634.41)</b>	<b>(1,861,771.16)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(5,408,843.96)	(5,295,634.41)
51220	Тайлант үеийн үр дүн	113,209.55	3,433,863.25
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	507,064.00	507,064.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>65,067,544.83</u></b>	<b><u>65,324,443.22</u></b>

## 2.2 Аудит хийсэн ор дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>45,673,449.29</b>	<b>61,728,567.29</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>45,673,449.29</b>	<b>61,728,567.29</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>45,673,449.29</b>	<b>61,728,567.29</b>
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>45,673,449.29</b>	<b>61,728,567.29</b>
110002	Үйл ажиллагааны орлого	44,053,449.29	60,108,567.29
110003	Хөрөнгийн орлого	1,620,000.00	1,620,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>45,560,239.74</b>	<b>57,913,163.67</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>45,560,239.74</b>	<b>57,913,163.67</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>45,560,239.74</b>	<b>57,913,163.67</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>10,158,629.00</b>	<b>11,042,681.00</b>
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	10,158,629.00	11,042,681.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,465,166.15</b>	<b>1,369,600.87</b>
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	1,465,166.15	1,369,600.87
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>5,900.00</b>	<b>-</b>
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	5,900.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>282,560.00</b>	<b>275,000.00</b>
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	282,560.00	275,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>30,996,245.31</b>	<b>42,680,971.13</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,996,245.31	42,680,971.13
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>806,739.40</b>	<b>679,244.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	638,551.46	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	62,700.00	53,600.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	92,909.10	625,644.00
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	12,578.84	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,844,999.88</b>	<b>1,865,666.67</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,844,999.88	1,865,666.67
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>113,209.55</u></b>	<b><u>3,815,403.62</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>113,209.55</u></b>	<b><u>3,815,403.62</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>50,203,913.00</u>	<u>64,266,989.00</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	50,203,913.00	64,266,989.00
110	Орлогын албан татвар	50,203,913.00	64,266,989.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	50,203,913.00	64,266,989.00
110002	Үйл ажиллагааны орлого	50,203,913.00	64,266,989.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>50,365,391.73</u>	<u>63,843,818.82</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,365,391.73	63,843,818.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,365,391.73	63,843,818.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,344,539.00	9,093,845.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	8,344,539.00	9,093,845.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,617,068.15	2,628,780.87
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	2,617,068.15	2,628,780.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	745,600.00	-
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	745,600.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	34,531,477.60	48,132,330.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	34,531,477.60	48,132,330.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,126,706.98	3,988,862.95
210815	Хүүний төлбөрт төлсөн /ТӨҮГ/	1,288,152.00	-
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	2,737,754.98	3,104,662.95
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	100,800.00	884,200.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(161,478.73)</u>	<u>423,170.18</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	51,940.00
140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт	-	51,940.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	51,940.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(161,478.73)	475,110.18
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	286,255.47	124,776.74
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	124,776.74	599,886.92

### 2.4 Аудит хийсэн цэвэр өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	9,215,613.00	507,064.00	-5,295,634.41	152,000.00	4,579,042.59
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,207,613.00	507,064.00	-5,295,634.41	152,000.00	4,571,042.59
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,207,613.00	507,064.00	-5,295,634.41	152,000.00	4,571,042.59
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	9,207,613.00	507,064.00	-5,295,634.41	152,000.00	4,571,042.59

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,207,613.00	507,064.00	-5,295,634.41	152,000.00	4,571,042.59
D08	Тайлант үеийн үр дүн			3,433,863.25		3,433,863.25
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,207,613.00	507,064.00	-1,861,771.16	152,000.00	8,004,905.84

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	50078019.51	57913163.67
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2918291.88</b>	<b>2544910.67</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>34795000.00</b>	<b>42955971.13</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>10990869.00</b>	<b>11042681.00</b>
210101	Үндсэн цалин	10990869.00	11042681.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1373858.63</b>	<b>1369600.87</b>
210201	Тэтгэврийн даатгал	1373858.63	1369600.87
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20000.00</b>	<b>0.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	20000.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>360000.00</b>	<b>275000.00</b>
210401	Бичиг хэрэг	60000.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300000.00	275000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>34435000.00</b>	<b>42680971.13</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	34435000.00	42680971.13
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>630000.00</b>	<b>338244.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	560000.00	284644.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	70000.00	53600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>400000.00</b>	<b>341000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400000.00	341000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1868291.9</b>	<b>1865666.7</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1868291.9</b>	<b>1865666.7</b>
223001	Бусад хөрөнгө	1868291.88	1865666.67

## 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага үйл ажиллагааныхаа зорилгоо “ард иргэдийг эрүүл аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах үйл ажиллагаа явуулдаг байгууллага” гэж тодорхойлсон байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулаагүй, дотооддоо хяналт шалгалтын баг зохион байгуулаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өмнөговь аймгийн Мандал-овоо сумын аргамжинцэцэг ОНӨААТҮГ-н 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өмнөговь аймгийн Мандал-овоо сумын аргамжинцэцэг ОНӨААТҮГ-н 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар баталсан “Аж ахуй нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 0.2 сая төгрөгөөр буюу 0.39 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	124,776.74	599,886.92	475,110.18
Бараа материал	5,391,481.61	5,212,501.49	-178,980.12
Үндсэн хөрөнгө	58,386,000.40	56,906,333.73	-1,479,666.67
<b>Нийт хөрөнгө</b>	<b>65,067,544.83</b>	<b>65,324,443.23</b>	<b>256,898.40</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,359,613.00	9,359,613.00	0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>65,067,544.83</b>	<b>65,324,443.23</b>	<b>256,898.40</b>

Дээрх хүснэгтээс харахад үндсэн хөрөнгө өмнөх оны үзүүлэлтээс нөлөөлөхүйц өөрчлөлт гараагүй байна. Бараа материал өмнөх оны нөөцөөс зарцуулсан, үндсэн хөрөнгө аймгийн иргэдийн төлөөлөгчийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 9/75 тоот тогтоолыг үндэслэн 316,420.00 төгрөгийн өртөг бүхий 4 нэр төрлийн 7 хөрөнгийг дахин үнэлж нийт 260.000.00 төгрөгийн хөрөнгийг орлогодож авсан байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дүгээр зүйлийн 1.2-д заасны дагуу “Аргамжинцэцэг” ОНӨААТҮГ-ын захирал Ц.Ууганцэцэг нь зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангаж эдийн засгийн үр дүн, хүрэх түвшинг батлуулсан байна.

Гүйцэтгэлээр борлуулалтын орлогоор 61.7 сая төгрөг, нийт 61.7 сая төгрөгийг бүрдүүлж, 57.9 сая төгрөгийг зарцуулан, 3.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өмнөговь аймгийн Мандал-овоо сумын аргамжинцэцэг ОНӨААТҮГ-н 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх ТӨҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Т.Будсүрэн гүйцэтгэж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Ж.Болормаа, чанарын хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Өмнөговь аймгийн Мандал-овоо сумын аргамжинцэцэг ОНӨААТҮГ-н 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 50.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.5 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлыг санхүүжүүлээгүй байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторовын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 162 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"-д заасантай нийцэхгүй байна.

##### Шийдвэрлэсэн нь:

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг үнэн зөв, тогтоосон хугацаанд тогтмол тусгаж байх зөвлөмж өгсөн.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	Байхгүй.				
Албан шаардлага	Байхгүй.				
Зөвлөмж	Байхгүй.				
<b>Нийт дүн</b>					

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарал татахуйц анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар орлого үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны гүйцэтгэлийг аудитын явцад залруулах, 125.5 сая төгрөгийн 3 алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж, 2.5 сая төгрөгийн 2 алдааг дахин гаргахгүй байх 1 албан шаардлага өглөө.

#### **5.1 Төлбөрийн акт:**

Аудитаар төлбөрийн акт гараагүй байна.

#### **5.2 Албан шаардлага**

Илрүүлэлт-1: Санхүүгийн тайланд тусгасан 1,908,721.00 төгрөгийн авлага, 619,537.38 төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"-д заасантай нийцэхгүй байна.

#### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт-1: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж-1: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдүүлж ажиллах

2. Цахим төлбөрийн системтэй холбоотой асуудал:

#### Илрүүлэлт-2:

Өгсөн зөвлөмж-2: Цахим төлбөрийн системд худалдаж авсан бараа материалыг нэр төрлөөр бус бөөн дүнгээр шивэлт хийсэн нь Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх" заалттай нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж-2: Бараа, үйлчилгээ худалдан авалт хийх тухай бүрд борлуулагчийн хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг кассын машинаас хэвлүүлэн авч анхан шатны баримтад хавсаргаж байх зөвлөмж өгсөн.

3. Шилэн данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт-3: Шилэн дансны цахим хуудсанд 162 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж-3: Мэдээллийг тогтоосон хугацаанд, шуурхай мэдээлдэг байх зөвлөмж өгсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Орлого үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.	1	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй	1	125,572,386.11	0	0	0	0	0	0	0	0	0	1	125,572,386.11
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>125,572,386.11</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>125,572,386.11</b>

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТ-ны тоо	Тоо	Дүн
Өглөг, авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, үндсэн хөрөнгөнд тооллого хийгээгүй.	2	2,528,258.38	0	0	1	2,528,258.38	0	0	0	0	0	0

Цахим төлбөрийн системд худалдаж авсан бараа материалыг нэр төрлөөр бус бөөн дүнгээр шивэлт хийсэн	1	0	0	0	0	0	0	0	0	1	0	0	0	0
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>2,528,258.38</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>2,528,258.38</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/													
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил														
Шилэн дансны цахим хуудсанд 162 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна	1	0										1		0
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>0</b>										<b>1</b>		<b>0</b>